

СИСТЕМИЙН НӨЛӨӨ БҮХИЙ БАНКНУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН ТОЙМ СУДАЛГАА

2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК-ийн зүгээс харилцагчдадаа зориулан бэлтгэдэг энэ удаагийн судалгаагаар системийн нөлөө бүхий 5 банк, МХБ-д бүртгэлтэй Богд банк, 2.4 их наяд төгрөгийн хөрөнгөтэй Капитрон банк зэрэг нийт 7 банкны 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хийсэн харьцуулсан тойм судалгааг та бүхэнд хүргүүлж байна.


1. Салбарын тойм (Үйл ажиллагаа явуулж буй банкнуудаар)

Салбарын нийт актив 2024 оны эхний хагас жил (2024 оны 05 дугаар сар)-ийн эцсийн байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.9%-иар өсөж, 57,565.9 тэрбум төгрөгт хүрсэн бол нийт цэвэр зээлийн хэмжээ 25.1%-иар нэмэгдэж, 29,473.7 тэрбум төгрөг болоод байна.


Бүтцийн хувьд авч үзэхэд банкнуудын зээлийн багцын хэмжээ нийт активын 51.2%-ийг эзэлж байгаа бол үнэт цаас /цэврээр/-нд хийсэн хөрөнгө оруулалтын дүн (1,641.4 тэрбум) 2.9%-ийг бүрдүүлж байна.

Чанаргүй зээлийн хувь нийт зээлийн 5.4%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.2%-иар буурсан үзүүлэлт байна.

Зураг № 1. Салбарын нийт актив, цэвэр зээлийн дүн, их наяд төгрөгөөр



Зураг № 2. Салбарын өсөлт, %-иар



Эх сурвалж: Монголбанк, Үйл ажиллагаа явуулж буй банкуудын тайлан

Эх үүсвэрийн бүтцийг голлох ангиллаар авч үзэхэд нийт эх үүсвэрийн 22.9%-ийг аж ахуй нэгж, иргэдийн харилцахаар, 38.6%-ийг хадгаламжаар, 11.1%-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.


2. Санхүү байдлын тайлан

Нэн тэргүүнд тайлант хугацаанд банкнуудын санхүүгийн байдал ямар нөхцөл байдалтай байгааг авч үзье.

Активын бүтэц

Активын бүтцийг ерөнхийд нь түргэн хөрвөх хөрөнгө, хөрөнгө оруулалт, зээл болон бусад гэсэн 4 хэсэгт хуваан авч үзсэн бөгөөд тэдгээрийг өөрийн нийт активт эзлэх жингээр нь харьцуулалт хийн Зураг №2-т харуулав.

Зураг № 3. Активын бүтэц, %-иар



Эх сурвалж: Санхүүгийн тайлангууд, МХБ болон банкнуудын албан ёсны цахим хуудас

✓ Харилцагчдад олгосон зээл

Банкнуудын үндсэн үйл ажиллагаа нь зээл олголт бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь дунджаар нийт активын 50.8%-ийг эзэлж байна.

Зээлийн активыг нийт хөрөнгөд харьцуулан банк тус бүрээр авч үзэхэд Хас банк хамгийн өндөр буюу 58.6%-иар тэргүүлж байгаа бол Богд банк 54.9%-иар удаалж, харин Капитрон банкных 38.3%-тай байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

✓ Түргэн хөрвөх хөрөнгө

Банкнүүд нийт активын дунджаар 34.0%-ийг түргэн хөрвөх хөрөнгөд байршуулсан байгаа бол Капитрон банк хамгийн өндөр буюу 51.8%-ийг, Худалдаа хөгжлийн банк 39.8%-ийг, харин Хас банк хамгийн бага буюу 17.4%-ийг тус тус түргэн хөрвөх хөрөнгөд байршуулсан байна. *Энэхүү ангилалд “Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө”-ийн дүнг оруулсан бөгөөд үүнд үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт (Засгийн газрын үнэт цаас гэх мэт)-ыг оруулаагүй болно.

✓ Хөрөнгө оруулалт


Харин банкнүүд нийт активынхаа дунджаар 9.3%-ийг үнэт цаасанд байршуулсан байгаа бол энэ үзүүлэлтээр Хас банк 20.0%-иар, Богд банк 9.0%-иар

тус тус тэргүүлж, харин Худалдаа хөгжлийн банк хамгийн бага буюу 6.2%-ийг үнэт цаасанд байршуулсан байна.

Пассивын бүтэц

Пассивын бүтцийг нийт 6 хэсэгт хуваан авч үзсэн бөгөөд үүнээс голлох үзүүлэлт болох харилцах, хадгаламж, банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, өөрийн хөрөнгө гэсэн хэсгүүдийг энд онцлон хүргэж байна.

Зураг № 4. Пассивын бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн тайлангууд, МХБ болон банкнуудын албан ёсны цахим хуудас

✓ Харилцах

Банкнууд дунджаар нийт эх үүсвэрийн 22.4%-ийг харилцах дансаар татсан ба энэхүү үзүүлэлтээр Төрийн банк хамгийн өндөр буюу 29.6%-ийг, ХХБ 29.4%-ийг, харин Богд банк хамгийн бага буюу 4.8%-ийг тус бүр харилцах дахь харилцагчдын мөнгөн хөрөнгөөр бүрдүүлсэн байна.

✓ Хадгаламж

Нийт эх үүсвэрийн дунджаар 39.1%-ийг банкнууд хадгаламжаар бүрдүүлсэн бол Хаан банк энэхүү үзүүлэлтийг 44.7%-иар тэргүүлж, 43.7%-иар Төрийн банк удаалж байна. Харин Голомт банк 31.0% гэсэн үзүүлэлтээр хамгийн бага хадгаламж татсанд тооцогдож байна.

✓ *Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл*

Богд банк нийт эх үүсвэрийн 28.4%-ийг, Хас банк 25.4%-ийг банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлээр санхүүжүүлсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа бол Төрийн банк 10.9%-тай байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

✓ *Өөрийн хөрөнгө*

Банкнууд дунджаар нийт эх үүсвэрийнхээ 11.4%-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа ба энэхүү үзүүлэлтээр Богд банк хамгийн өндөр буюу 17.7%, Хас банк 11.8%-иар тус тус тэргүүлж, харин Капитрон банк 8.9% байгаа нь хамгийн багад тооцогдож байна.


3. Өсөлтийн хандлага /Тренд/

Нийт актив болон цэвэр зээлийн өсөлт

Банкнуудын нийт актив тайлант хугацаанд дунджаар 31.8%-иар өссөн бол Богд болон Төрийн банкууд тус бүр 42.2%, 36.6%-иар өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт болсон байна.

Харин цэвэр зээлийн өсөлт дунджаар 38.6%-иар нэмэгдсэн бол Богд банк хамгийн өндрөөр буюу 64.1%-иар, Голомт банк 59.1%-иар тус тус цэвэр зээлийн дүнгээ өсгөсөн байна. Хаан банк хувьд цэвэр зээлийн өсөлт 22.2%-тай байгаа нь хамгийн бага өсөлт болсон байна.

Зураг № 5. Нийт актив болон цэвэр зээлийн өсөлт, %-иар




Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

Хүүгийн орлого

Банкнудын хүүгийн болон цэвэр хүүгийн орлого 2024 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс дунджаар 36.8% болон 25.9%-иар тус тус өссөн нь орлогын өсөлт харьцангуй сайн байгааг харуулж байгаа бөгөөд хүүгийн орлогын өсөлтөөр Богд банк 55.3.0%-иар тэргүүлсэн бол ХХБ 49.6%-иар удаалсан байна.

Цэвэр хүүгийн орлогын өсөлтөөр ХХБ 89.9%-иар, Хас банк 37.2%-иар тус тус өссөнөөр банкуудаа тэргүүлсэн бол Капитрон банкны цэвэр хүүгийн орлого 15.6%-иар буурсан нь хамгийн тааруухан үзүүлэлт болсон байна.

Зураг № 6. Хүүгийн болон цэвэр хүүгийн орлогын өсөлт, %-иар




Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

Хүүгийн зардал

2024 оны эхний хагас жилийн байдлаар хүүгийн зардал өмнөх оны мөн үетэй харьцуулахад дунджаар 52.1%-иар (голч үзүүлэлт 44.0%) нэмэгдсэн бөгөөд Богд банк 119.1%-иар, Капитрон банк 56.0%-иар тус тус нэмэгдсэнээр бусдыгаа тэргүүлсэн байна. Энэ нь эх үүсвэр татах үйл ажиллагаа нэмэгдсэн эсхүл эх үүсвэрийн зардал нэмэгдсэн байх магадлалтай тул зардлын бүтцийг хамтатган авч үзэх нь зүйтэй юм. Харин ХХБ-ны хүүгийн зардал 27.6%-иар өссөн нь хамгийн бага үзүүлэлт болсон бол Хаан банкных 34.2%-иар нэмэгдсэн байна.

Эдгээр банкнудын хүүгийн орлого дунджаар 36.8%-иар өссөн ч хүүгийн зардал 44.0%-иар (голч үзүүлэлт) нэмэгдсэн байгаа нь **эх үүсвэрийн хэмжээ эсхүл өртөг** нэмэгдэж байгааг харуулж байна.

Зураг № 7. Хүүгийн зардлын өсөлт, %-иар




Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

4. Хүүгийн орлого, зардлын бүтэц


Хүүгийн зардлыг хүүгийн орлогод харьцуулсан байдлаар авч үзэхэд Хаан банк хамгийн бага буюу нийт хүүгийн орлогынхоо 51.4%-ийг хүүгийн зардалд зарцуулснаар бусдыгаа манлайлж байгаа бол, түүний араас Төрийн банк, ХХБ тус бүр 55.2%-иар удаалж байна.

Зураг № 8. Хүүгийн орлогод эзлэх хүүгийн зардлын хэмжээ, %-иар



Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

Зураг № 9. Хүүгийн зардлын өөрчлөлт, %-иар



Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

Дээрх зургаас харахад өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүүгийн орлогод эзлэх зардлын хэмжээ дунджаар 4.9%-иар нэмэгдсэн бол Хас банкны зардлын хувь хамгийн багаар буюу 1.2%-иар, Хаан банкных 2.4%-иар тус тус нэмэгдсэн байна. Харин ХХБ-ны хүүгийн орлогод эзлэх зардлын хэмжээ хамгийн ихээр буюу 9.5%-иар буурсан байгаа нь анхаарал татаж байна. Учир нь ХХБ-ны орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 49.6%-иар нэмэгдсэн ч зардлын хэмжээ 27.6%-иар өссөн нь цэвэр хүүгийн орлогын өсөлтийг хамгийн өндөр буюу 89.9%-д хүрэхэд нөлөөлсөн байна. Энэ нь тус банк эх үүсвэр татах зардлаа маш сайн бууруулсан байгааг харуулж байна.

Харин хүүгийн зардлын өсөлт хамгийн өндөр байсан Богд болон Капитрон банкнуудын хүүгийн орлогод эзлэх хүүгийн зардал хамгийн өндөр байгаагаас харвал эдгээр банкнуудын эх үүсвэрийн зардал тайлант хугацаанд хамгийн ихээр буюу 17.3% болон 14.6%-иар тус тус өссөн байгааг харуулж байна.

5. Санхүүгийн харьцаа үзүүлэлт


Банкнуудын санхүүгийн тайлангийн шинжилгээг “CAMEL” аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд харьцаа үзүүлэлт тус бүрээр шинжлэн тайлбарласан болно.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ / Capital adequacy

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн активт харьцуулсан бөгөөд энэхүү харьцаа үзүүлэлтийг Монголбанкнаас 12.0%-иас дээш байхаар зохицуулсан байдаг.

Ийнхүү тооцоход судалгаанд хамрагдсан банкнуудын үзүүлэлт Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүгд хангасан байгааг дараах зурагт харуулсан болно.

Зураг № 10. Өөрийн хөрөнгө / Эрсдэлээр жигнэсэн активын харьцаар



Эх сурвалж: Банкнуудын тайлан


Энэхүү харьцааны үр дүн өндөр байх тусмаа сайн буюу өөрийн хөрөнгийн хэмжээ нь эрсдэлээр жигнэсэн активд эзлэх хувь нэмэгдэх тусам эрсдэл багатай байна гэж үзэх юм.

Активын чанар / Asset quality

Активын чанарын үзүүлэлтийг төлөөлүүлэн нийт зээлд эзлэх “Чанаргүй зээлийн хэмжээ”-г хувиар авч үзсэн бөгөөд хамгийн бага чанаргүй зээлтэй банкаар Хас банк 2.2%-иар тэргүүлж, Голомт банк 3.2%-иар удаалсан бол ХХБ-ны үзүүлэлт 7.3%-тай байгаа нь хамгийн тааруухан үзүүлэлт болж байна.

Ерөнхийд нь авч үзвэл банкнуудын чанаргүй зээлийн хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үе болон жилийн эцэстэй харьцуулахад тогтвортой буурсан дүр зурагтай байна.

Зураг № 11. Чанаргүй зээлийн хувь




Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

Менежмент / Efficiency ratio

Үр ашигт байдлын харьцаа үзүүлэлт нь тухайн банкны удирдлага өөрийн активыг хэрхэн үр ашигтай удирдаж байгааг харуулдаг бөгөөд харьцаа үзүүлэлтийн дүн бага байх тусам тухайн банкны удирдлага илүү бага зардлаар тайлант хугацаанд үйл ажиллагаагаа удирдан ашиг орлогоо нэмэгдүүлж байгааг харуулдаг юм.

Зураг № 12. Үр ашигт байдлын харьцаа



Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

Үр ашигт байдлын харьцаагаар авч үзэхэд Голомт банк хамгийн бага зардлаар буюу нийт орлогын (эрсдэлийн сангийн зардлыг хассан) 32.3%-тай (өнгөрсөн оны мөн үеэс даруй 37.4%-иар сайжирсан) дүйцэх хүүгийн бус зардлыг гаргасан байгаа бол Хас банк 40.3%-иар удаалж, Капитрон банк 94.4%-иар сүүл мушгисан байна.


Ашигт ажиллагаа / Earnings

Тайлант хугацаант банкнуудын ашигт ажиллагааны түвшнийг эздийн өмчийн өгөөж /ROE/, нийт хөрөнгийн өгөөж /ROA/ болон цэвэр ашгийн ахиуц /Net profit/ гэсэн 3 үзүүлэлтээр авч үзсэн болно.

Зураг №14-өөс харахад банкнууд эздийн өмчийн өгөөжийг дунджаар 24.7%-иар өсгөсөн бол Голомт банкны эзэд хамгийн өндөр буюу 37.9%-ийн, Хаан банкных 29.5%-ийн өгөөж хүртсэнээр удаалж байна. Харин Төрийн банк 17.1%-иар эздийн өмчөө өсгөсөн нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Нийт хөрөнгийн өгөөжийн дундаж үзүүлэлт 2.9% байгаа бөгөөд энэхүү үзүүлэлтээр Богд банкны хамт олон нийт активаа 3.9%-ийн өгөөжтэй удирдсан бол түүний араас Голомт банк 3.5% гэсэн үзүүлэлтээр удаалж байна. Төрийн болон Капитрон банкнуудын хувьд тус бүр 1.9%, 1.7% байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Зураг № 13. Эздийн өмчийн өгөөж /ROE/, Нийт активын өгөөж /ROA/, Цэвэр ашгийн ахиуц /Net profit/



Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

Түүнчлэн хүүгийн болон хүүгийн бус нийт орлогод харьцуулсан цэвэр ашгийн ахиуцын хэмжээгээр Голомт банк 51.7%-иар, Хас банк 44.9%-иар тус тус тэргүүлсэн бол Капитрон банк 5.0%-ийн үзүүлэлттэйгээр жагсаалтын сүүлд бичигдсэн байна.

Хөрвөх чадварын харьцаа / Liquidity ratio

Банкнудын хөрвөх чадварыг тодорхойлохдоо нийт зээлийг хадгаламж, харилцахын дүнд харьцуулах, мөн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын гэсэн 2 төрлийн харьцааг ашигласан болно.

Нийт зээлийг нийт хадгаламж, харилцахын дүнд харьцуулсан харьцаа нь банк хадгаламж, харилцахаар татсан эх үүсвэрийн хэдэн хувийг зээл хэлбэрээр гаргаж байгааг харуулах зорилготой юм.

Энэхүү харьцааны үзүүлэлтийн дүнгээр Богд банк хамгийн өндөр буюу 126.8%-ийг зээл болгон гаргасан бол түүний араас Хас банк 103.8%-иар удаалж байна.

Хэдий энэхүү үзүүлэлт нь өндөр байх тусам сайн байдаг ч 90%-иас дээш байх тохиолдолд хэт их зээл гаргаснаар хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үздэг.

Тиймээс дээрх үзүүлэлтийг төлбөр түргэн гүйцэтгэх харьцааны үзүүлэлттэй хамтатган харах нь зүйтэй.

Зураг № 14. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт



Эх сурвалж: Банкнуудын тайлан, шинжээчийн тооцоолол

Төлбөр түргэн гүйцэтгэх харьцааны үзүүлэлт (банкнуудын 2024 оны эхний хагас жилийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланд тусгасан)-ээр Капитрон банк 47.5% гэсэн үзүүлэлтээр тэргүүлж байгаа бол Хаан банк 45.2%-иар удаалж байна. Уг үзүүлэлтийн зохистой харьцааг Монголбанкнаас 25.0%-иар тогтоосон бөгөөд үүнтэй харьцуулахад эдгээр банкнуудын үзүүлэлт харьцангуй өндөр байгааг харж болохоор байна.

6. Ногдол ашиг

Хөрөнгө оруулагчдын хувьд хувьцаа худалдан авахаас өмнө зайлшгүй харгалзан үзэх бас нэгэн хүчин зүйл бол тухайн компанийн ногдол ашгийн бодлого болоод ногдол ашиг тараалтын хувь хэмжээ байдаг.

Хүснэгт № 1. МХБ-ээр арилжаалагддаг банкнуудын ногдол ашгийн мэдээлэл

Банкны нэр	ЦА*-ийн дүн /сая төг/	ЦА-ын эзлэх хувь	Нэгж хувьцаанд НА**	НА-ийн өгөөж /2023/	Хувьцааны ханш***	НА* зарласан дүн /2024Н1/	НА-ийн өгөөж /2024Н1/	Бүртгэлийн өдөр
Хас	85,309.0	9.7%	81.04	6.4%	747.11	18.0	2.4%	2024.08.08
Хаан	290,440.0	32.9%	151.89	11.8%	1085.00	-	0.0%	-
Голомт	273,138.0	30.9%	337.77	9.9%	1119.00	-	0.0%	-
Төрийн	44,782.7	5.1%	59.31	11.8%	485.19	-	0.0%	-
ХХБ	174,144.5	19.7%	3,441.53	3.1%	25,100.00	1,033.0	4.1%	2024.07.24
Богд	15,011.2	1.7%	12.01	6.6%	81.88	3.0	3.7%	2024.07.02

* ЦА – Цэвэр ашиг

** НА - Ногдол ашиг

*** Хаалтын ханш (2024 оны 07-р сарын 25 өдөр)

Энэхүү судалгааны хүрээнд авч үзсэн банкнуудаас 3 банк 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хувиарлахаар шийдвэрлэсэн байна.

Худалдаа хөгжлийн банк нэгж хувьцаандаа 1,033.0 төгрөгийн ногдол ашгийг тараахаар болсон нь хөрөнгө оруулагчдын өгөөжийг 4.1%-иар нэмэгдүүлж байгаа бол Хас банк 2.4%-ийн, Богд банк 3.7%-ийн ногдол ашгийн өгөөжийг тус тус хөрөнгө оруулагчдадаа олгохоор шийдвэрлэсэн байна.

Бусад банкнуудын хувьд одоогоор 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах шийдвэр гаргаагүй байгаа болно.

Капитрон банк нь хаалттай хүрээнд үйл ажиллагаа эрхлэн явуулдаг банк юм.

7. Үнэ/ашиг, Үнэ/Дансны үнийн харьцаа үзүүлэлт

Хөрөнгө оруулагчдын хувьд хувьцаа худалдан авахаас өмнө тухайн хувьцааны үнэлгээг үнэ/ашиг, үнэ/дансны үнийн харьцаа үзүүлэлтээр жишиж харах хандлагатай байдаг бөгөөд энэ хүрээнд нээлттэй 6 банкны үзүүлэлтийг дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт № 2. МХБ-ээр арилжаалагддаг банкнуудын хувьцааны үнийн харьцаа үзүүлэлтийн талаарх мэдээлэл

Банкны нэр	Цэвэр ашгийн дүн /сая төг/	Нэгж хувьцаанд ногдох ашиг	Эздийн өмч /сая төг/	Хувьцааны ханш**	P/E	P/B
Хас банк	85,309.0	81.0	664,513.0	747.1	9.2	1.2
Хаан банк	290,440.0	151.9	2,118,331.0	1,085.0	7.1	1.0
Голомт банк	273,138.0	337.8	1,136,384.0	1,119.0	3.3	0.8
Төрийн банк	44,782.7	59.3	568,186.9	485.2	8.2	0.6
ХХБ	174,144.5	3,441.5	1,398,964.3	25,100.0	7.3	0.9
Богд банк	15,011.2	12.0	148,566.4	81.9	6.8	0.7

Үнэ/дансны үнийн харьцаа үзүүлэлтээр хамгийн өндөр нь Хас банк 1.2 гэсэн харьцаа үзүүлэлттэй байгаа бол бусад нь 1.0 болон түүнээс доош үзүүлэлттэй байна.

Харин үнэ/ашгийн харьцаа үзүүлэлтээр хамгийн өндөр нь Хас банк 9.2-иар тэргүүлж байгаа бол бусад банкны үзүүлэлт түүнээс бага байна.

Үүнээс харахад банкнуудын хувьцаа харьцангуй хямд үнэлэгдсэн байх магадлалтай бөгөөд хөрөнгө оруулагч та бүхэн худалдан авалт хийхдээ тухайн банкыг илүү дэлгэрэнгүй судлах нь зүйтэй юм.

8. ДҮГНЭЛТ

Банкнуудын үндсэн үйл ажиллагаа нь зээл олгох бөгөөд энэ ч утгаараа нийт активынхаа дийлэнх хувийг зээлийн багцад байршуулсан байдаг. Тиймээс банкнууд Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон бусад шаардлагуудыг хангасны үндсэн дээр аль болох өндөр өгөөж хүртэх зээлийн санхүүжилт гаргах нь түргэн хөрвөх хөрөнгөд байршуулснаас илүүтэй ашиг орлогоо нэмэгдүүлэх магадлалтай юм.

Энэ тал дээр Хас банк бүтцийн хувьд хамгийн өндөр хувиар зээл гаргасан бөгөөд бусад банкуудын хувьд ч мөн өнгөрсөн оны жилийн эцэстэй харьцуулахад илүү өндөр хувиар зээл гаргасан нь цаашид ашиг орлогоо өсгөх суурь нөхцлийг бүрдүүлсэн байна.

Олон улсад харилцах болон хадгаламжаар татсан эх үүсвэр нь хамгийн зардал багатай эх үүсвэрт тооцогддог бол Монголын нөхцөлд гадаадын банк, санхүүгийн байгууллагаас хямд өртөгтэй зээл авах нь мөн дээрхээс дутахгүй давуу талыг тухайн банканд авч ирж болох юм.

Тиймээс хамгийн тогтвортой эх үүсвэр болох хадгаламжийн бүтээгдэхүүнээр Хаан банк нийт эх үүсвэрийнхээ 44.7%-ийг, Төрийн банк 43.7%-ийг бүрдүүлсэн байгаа бол банк санхүүгийн байгууллагаас авсан зээлээр Богд банк 28.4%-ийг, Хас банк 25.4%-ийг тус тус бүрдүүлсэн байна.

Харилцахаар бүрдүүлсэн эх үүсвэр нь зардлын хувьд харьцангуй хямд ч харилцагчид өдөр тутмын зардалдаа зориулан төрөл бүрийн зарлагын гүйлгээг хүссэн үедээ хийх боломжтой байдаг нь эх үүсвэр талаас харьцангуй тогтворгүй харагдаж байна. Гэхдээ байгууллагын банкны үйл ажиллагаа түлхүү эрхэлдэг Голомт болон ХХБ-ууд нь тус бүр 27.7%, 29.4%-ийг харилцах дансаар бүрдүүлсэн байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд үүнийг бизнесийн өөрийн онцлогтой холбон үзэх нь зүйтэй юм.

Банкнудыг санхүүгийн харьцаа үзүүлэлтийн шинжилгээний үр дүнгээр дүгнэн үзэхэд Хас банк өөрийн хөрөнгийн хүрэлцээ өндөр, чанаргүй зээлийн хувь хамгийн бага, удирдлагын ур чадварыг хэмждэг үр ашигт ажиллагааны үзүүлэлт хамгийн сайн, ашигт ажиллагааны үзүүлэлт болох цэвэр ашгийн ахиуц өндөр, нийт зээлийн харилцах, хадгаламжийн дүнд харьцуулсан харьцаа өндөр, ногдол ашиг жилд 2 удаа олгодог зэрэг дийлэнх үзүүлэлтээр, харин Хаан банк эздийн өмчийн өгөөж болон нийт хөрөнгийн өгөөж сайн, нийт зээлийн харилцах, хадгаламжийн дүнд харьцуулсан харьцаа хамгийн оновчтой, ногдол ашгийн хувь хамгийн өндөр, хүүгийн зардлын орлогод эзлэх хувь хамгийн бага зэрэг үзүүлэлтүүдээр бусдыгаа манлайлж байгааг харж болохоор байна.

Мөн Голомт банкны хувьд ашигт ажиллагаа хамгийн өндөр, удирдлагын ур чадварыг харуулдаг үр ашигт байдлын харьцаа хамгийн сайн, чанаргүй зээлийн хэмжээг маш сайн бууруулж чадсан зэрэг голлох үзүүлэлтүүдээр 2024 оны эхний хагас жилд бусдыгаа манлайлж байна.

Жич: Энэхүү харьцуулсан тойм судалгаа нь зөвхөн Монгол Улсын ТОП-5 банк, МХБ-д бүртгэлтэй Богд банк, хаалттай хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг Капитрон банк зэрэг нийт 7 банкны санхүүгийн тайланд үндэслэн боловсруулсан бөгөөд харьцуулалтыг энэ хүрээнд хийсэн болохыг дурдах нь зүйтэй.

Мөн судалгааны дүгнэлт нь зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн бөгөөд дээрх дүгнэлтэд үндэслэн гүйцэтгэсэн аливаа арилжааны эрсдэлийг компани болон шинжээч хариуцахгүй болохыг үүгээр мэдэгдэж байна. Тиймээс та хөрөнгө оруулалтын шийдвэрээ БИЕ ДААН гаргана уу!